



COWI

EBP



ИКОН ХХК

ХОГ ХАЯГДЛЫН САЛБАРЫН ХУУЛЬ ЭРХ ЗҮЙН ХУРААНГУЙ ГАРЫН АВЛАГА

ХОГ ХАЯГДЛЫН ОЛОН НИЙТИЙН БАЙЦААГЧ БОЛОН
ХЭСГИЙН АХЛАГЧ НАРТ ЗОРИУЛАВ

УЛААНБААТАР ХОТ
2022 ОН

УЛААНБААТАР ХОТЫН АХУЙН ХОГ ХАЯГДЛЫН ЦУГЛУУЛАЛТ, ТЭЭВЭРЛЭЛТИЙН МЕНЕЖМЕНТ ТӨСӨЛ

Хэрэгжүүлэгч



УЛААНБААТАР ХОТЫН
ЗАСГИЙН ГЭРЛЭГ
АЛБА



Schweizerische Eidgenossenschaft
Confédération suisse
Confederazione Svizzera
Confederaziun svizra

Swiss Agency for Development
and Cooperation SDC
Швейцарын хөгжлийн агентлаг

COWI EBP



ИКОН ХХК

Энэхүү өврийн дэвтрийг хорооны хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагчийн хог хаягдлын хууль эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, олон нийтэд хог хаягдлын талаарх хууль, журмуудыг танилцуулахад гарын авлага болгох зорилгоор Швейцарын хөгжлийн агентлагийн санхүүжилтээр хэрэгжиж буй Улаанбаатар хотын Ахуйн Хог Хаягдлын Цуглуулалт Тээвэрлэлтийн Менежмент Төслөөс санаачлан Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль, Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах журам, Хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах, мөнгөн урамшуулал олгох журмуудаас хорооны хэсгийн ахлагч, олон нийтийн байцаагчдын өдөр тутмын үйл ажиллагаанд шаардлагатай бүлэг, зүйл, заалтыг түүвэрлэн авч боловсруулав.

АГУУЛГА

НЭГ. ХОГ ХАЯГДЛЫН ТУХАЙ ХУУЛЬ 4

Хуулийн зорилт	5
Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх	5
Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг	7
Хог хаягдлын үйлчилгээний хураамж, төлбөр, үйл ажиллагааны санхүүжилт	9

ХОЁР. ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬ 10

Хуулийн зорилго	11
Торгох шийтгэл	11
Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах	11
Танхайрах	12
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах	12
Хог хаягдлын тухай хууль зөрчих	12

ГУРАВ. ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ, АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ, ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ 20

Нийтлэг үндэслэл	21
Дүүрэг, хорооны засаг дарга болон аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн чиг үүрэг	21
Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах	25
Энгийн хог хаягдлыг ангилах	25

ДӨРӨВ. ХОГ ХАЯГДЛЫН ОЛОН НИЙТИЙН БАЙЦААГЧ АЖИЛЛУУЛАХ, МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ ЖУРАМ 26

Нийтлэг үндэслэл	27
Олон нийтийн байцаагчид тавигдах шаардлага, түүнийг томилох	27
Олон нийтийн байцаагчийн чиг үүрэг, зөрчлийн тэмдэглэл үйлдэх	29



2017 оны 5 дугаар сарын 12-ны өдөр батлагдсан

Хуулийн зорилт

1.1. Энэ хуулийн зорилт нь хог хаягдлаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах, түүнээс урьдчилан сэргийлэх, хог хаягдлыг эдийн засгийн эргэлтэд оруулж, байгалийн нөөц баялгийг хэмнэх, иргэдийн хог хаягдлын талаархи боловсролыг дээшлүүлэх зорилгоор хог хаягдлыг бууруулах, ангилах, цуглуулах, тээвэрлэх, хадгалах, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, экспортлох болон аюултай хог хаягдлыг импортлох, хил дамжуулан тээвэрлэхийг хориглохтой холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын бүрэн эрх

Хог хаягдлын талаар сум, дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	• Энгийн хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх зардлын нэгж тарифыг батлах (Хуульд заасан аргачлалын дагуу); • Тухайн нутаг дэвсгэрт мөрдөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тогтоох (Хуульд заасан аргачлалын дагуу);	9 дүгээр зүйл. 9.2.
Хог хаягдлын талаар сум, дүүргийн Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	• Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; • Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаа эрхлэх аж ахуйн нэгж, байгууллагыг төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн дагуу сонгон шалгаруулж, гэрээ байгуулах; • Хог хаягдлын үйлчилгээний хураамжаас төвлөрсөн орлогыг энэ хуульд заасны дагуу зарцуулах; • Нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлүүлэх; • Хог хаягдлын талаархи боловсрол олгох сургалт, сурталчилгааг зохион байгуулах, дэмжлэг, туслалцаа үзүүлэх;	9 дүгээр зүйл. 9.4.

	• Хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагч ажиллуулах; • Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих; • Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх; • Иргэдийн бүлгийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлэх (хуульд заасны дагуу); • Нийтийн эдэлбэр газарт хогийн савыг хүртээмжтэй тоогоор байрлуулах; • Нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хилийн заагийг тогтоох; • Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн урамшууллыг жил бүрийн төсөвт тусгаж, батлуулах, зарцуулалтад хяналт тавих.	
Хог хаягдлын талаар баг, хорооны Засаг дарга дараахь бүрэн эрхийг хэрэгжүүлнэ:	• Нутаг дэвсгэрийн хэмжээнд хог хаягдлын тухай хууль тогтоомжийг хэрэгжүүлэх; • Хог хаягдлыг цэвэрлэх үйл ажиллагаанд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах; • Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төлөлтөд хяналт тавих; • Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэхэд дэмжлэг үзүүлэх; • Хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагаанд хяналт тавих; • Хог хаягдлын талаархи олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд иргэн, аж ахуйн нэгж, байгууллагыг татан оролцуулах; • Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах.	9 дүгээр зүйл. 9.5.

Хог хаягдлын талаар иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг

Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ЭРХ	Хууль тогтоомж зөрчсөн этгээдийн талаар төрийн болон нутгийн захиргааны байгууллагад мэдээлэх, хариуцлага хүлээлгэхийг эрх бүхий байгууллага, албан тушаалтнаас шаардах; Хог хаягдлын талаар мэргэжлийн байгууллагаас арга зүйн туслалцаа, зөвлөгөө авах.	10 дугаар зүйл. 10.1.
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын ҮҮРЭГ	Энгийн хог хаягдлаа ангилан ялгах; Хуульд заасан шаардлагыг хангасан хогийн савтай байх; Аж ахуйн нэгж, байгууллага нь эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагатай хог тээврийн үйлчилгээний гэрээ байгуулах, хог хаягдлаа хүлээлгэж өгөх, хяналт тавих; Хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх; Барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг төлөх; Нийтийг хамарсан цэвэрлэгээ, иргэдийн бүлгээс зохион байгуулсан үйл ажиллагаанд оролцох; Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх; Хог хаягдлыг бууруулах, ангилах, дахин ашиглах, зүй зохистой хаях талаар ажилтнууддаа сургалт зохион байгуулах, дадал зуршлыг хэвшүүлэх; Эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх; Нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх, байгууллагын дотоод болон гадна орчны цэвэрлэгээг хариуцах үүрэг бүхий нэгж, эсхүл ажилтантай байх; Хамгийн боломжит арга технологи, байгаль орчинд ээлтэй арга ажиллагааг нэвтрүүлэх замаар хог хаягдал, түүний сөрөг нөлөөллийг бууруулах; Хог хаягдлын талаархи хууль тогтоомж, стандартын шаардлагыг хангаж ажиллах;	10 дугаар зүйл. 10.2.

	Хог хаягдлын улмаас хүний эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулсан, учруулж болзошгүй байдал бий болсон тохиолдолд тухайн шатны Засаг дарга болон онцгой байдал, цагдаа, эрүүл мэндийн байгууллагад мэдэгдэх; Байгууллагынхаа ажилтнуудад хог хаягдлын менежментийн талаар сургалт зохион байгуулж, зохих мэдлэгийг эзэмшүүлэх, дадал зуршлыг хэвшүүлэх; Аж ахуйн нэгж, байгууллага нь хүний эрүүл мэнд, байгаль орчинд хог хаягдлаас үзүүлэх нөлөөллийг бууруулах шаардлагатай арга хэмжээг авах, аюулгүй ажиллагааг хангах.	
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад хог хаягдалтай холбоотой ХОРИГЛОХ ҮЙЛ АЖИЛЛАГАА	Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолойд хаях; Нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хог хаягдал хаях; Хог хаягдлыг ил задгай шатаах; Гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах; Хог хаягдлыг хогийн сав болон тогтоосон цэгээс бусад газарт хаях; Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах; Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулах, шашны болон зан үйлийн эд зүйлс	10.3.

Хог хаягдлын үйлчилгээний хураамж, төлбөр, үйл ажиллагааны санхүүжилт

Энгийн хог хаягдал үүсгэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллага бүр хог хаягдлын үйлчилгээний хураамж төлнө.	41 дүгээр зүйл.
Иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг үүсгэж байгаа хог хаягдлын хэмжээнээс хамааруулан тооцно.	
Айл өрхийн хэрэглээнээс үүсэх энгийн хог хаягдлын үйлчилгээний хураамжийг нэг иргэнээр тооцно.	
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг сум, дүүргийн төсөвт төвлөрүүлнэ.	
Хог хаягдлын үйлчилгээний хураамжийг эрчим хүч, хэрэглээний цэвэр, бохир ус, дулаан, орон сууц, нийтийн аж ахуйн үйлчилгээний төлбөртэй хамтатган хураах замаар төвлөрүүлж болно	

Хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлогыг дараахь үйл ажиллагааг санхүүжүүлэхэд зарцуулна:	• Хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх; • Хог хаягдлыг булшлах; • Хуульд заасны дагуу хог хаягдлын үйлчилгээний хураамж төвлөрүүлсэн тохиолдолд үйлчилгээний шимтгэл төлөх. • Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн тухай мэдээлэл өгсөн иргэнд уг мэдээлэл нь батлагдсан тохиолдолд зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож сум, дүүргийн Засаг дарга мөнгөн урамшуулал олгоно.	41.9.
---	--	--------------



2017 оны 5 дугаар сарын 11-ний өдөр батлагдсан

Хуулийн зорилго

1. Энэ хуулийн зорилго нь хууль, түүнд нийцүүлэн гаргасан захиргааны хэм хэмжээний актыг зөрчсөн үйлдэл, эс үйлдэхгүйг зөрчилд тооцох, түүнийг үйлдсэн хүн, хуулийн этгээдэд шийтгэл оногдуулах замаар шударга ёсны тогтолцоог бэхжүүлэхэд оршино.

Торгох шийтгэл

Энэ хуулийн тусгай ангид заасан хэмжээгээр шүүх, эрх бүхий албан тушаалтнаас мөнгөн төлбөр оногдуулахыг торгох шийтгэл гэнэ.	3.4 дүгээр зүйл
Торгох шийтгэлийн хэмжээ нь • Хувь хүнд 10 – 20 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг, • Хуулийн этгээдэд 100 – 200 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	
Хуульд зааснаар нэг торгуулийн нэгж нь нэг мянган төгрөгтэй тэнцүү байна. (1 нэгж = 1 000 төг)	
Энэ хуулийн тусгай ангид заасны дагуу торгох шийтгэлийг сонгож оногдуулахаар заасан зөрчилд оногдуулсан торгох шийтгэлийг тогтоосон хугацаанд биелүүлээгүй бол эрх бүхий албан тушаалтны саналаар шүүх баривчлах шийтгэлээр солино.	

Олон нийтийн газарт зүй бусаар биеэ авч явах

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
Олон нийтийн газар, авто зам, орон сууцны орчны газар, гудамж, талбайд бие зассан, эсхүл нус, цэр, тамхины иш, хог хаясан	Хувь хүн – 10 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр	5.1 дүгээр зүйл.
Согтууруулах ундаа хэрэглэхийг хориглосон газарт архидан согтуурсан , Ажил, үйлдвэрлэлийн зайлшгүй шаардлагатай нөхцөл, эсхүл заншлын дагуу хэрэглэж байгаагаас бусад тохиолдолд хот, суурин газарт биедээ хутга, эсхүл хүний биед гэмтэл учруулж болох тусгайлан бэлтгэсэн зэвсгийн чанартай зүйл авч явсан	Хувь хүн – 25 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр Мөн зэвсэг, хэрэгслийг хураана	

Танхайрах

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
Олон нийтийн газарт, эсхүл орон байранд: - Хэрүүл маргаан үүсгэж; - Бусдыг өдөөн хатгаж; - Бусдын амгалан тайван байдал алдагдуулж; - Олон нийтийг үл хүндэтгэж; - Үйлчилгээний болон дарааллын журам зөрчиж биеэ авч явах нийтээр хүлээн зөвшөөрөгдсөн хэм хэмжээг зөрчсөн, эсхүл аж ахуйн нэгж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан	Хувь хүн – 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр эсхүл албадан сургалтад хамруулж долоогоос гуч хоногийн хугацаагаар баривчлах шийтгэл оногдуулна.	5.2 дүгээр зүйл.
<i>Тайлбар: Энэ хуульд заасан “орон байр” гэж хүн байнга, түр амьдрахад зориулагдсан төрөл бүрийн орон сууц, байшин, гэр, урц, зочид буудал, амралт сувиллын газар, зуслангийн байр, майхан зэргийг ойлгоно.</i>		

Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгах

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
Орчиндоо аюул учруулж болох амьтныг зохих хамгаалалтгүй байлгасны улмаас хүний эрүүл мэндэд хөнгөн хохирол учруулсан	Хувь хүн – 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр мөн учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж	5.19 дүгээр зүйл.

Хог хаягдлын тухай хууль зөрчих

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
1. Аюултай хог хаягдлыг: 1.1. түр хадгалах; 1.2. цуглуулах; 1.3. тээвэрлэх; 1.4. дахин боловсруулах; 1.5. устгах; 1.6. бүртгэх; 1.7. тайлагнах журам зөрчсөн	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.1 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
2. Тээврийн хэрэгслийн болон барилгын хог хаягдлыг: 2.1. цэвэрлэх; 2.2. цуглуулах; 2.3. ангилах; 2.4. тээвэрлэх; 2.5. дахин боловсруулах; 2.6. сэргээн ашиглах; 2.7. устгах; 2.8. булшлах журам зөрчсөн	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.2 дүгээр зүйл.
3. Эрүүл мэндийн байгууллагын аюултай хог хаягдлыг: 3.1. ангилах; 3.2. цуглуулах; 3.3. тээвэрлэх; 3.4. дахин боловсруулах; 3.5. сэргээн ашиглах; 3.6. устгах журам, аргачлал, зааврыг зөрчсөн	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.3 дүгээр зүйл.
4. Харьяа нэгж, байгууллагад үүссэн болон цэргийн зориулалтаар ашиглаж байсан газарт үлдсэн галт зэвсэг, сум, галт хэрэглэл, тэсэрч дэлбэрэх болон химийн хорт бодис, тэдгээрийн үлдэгдлийг: 4.1. цуглуулах; 4.2. тээвэрлэх; 4.3. дахин боловсруулах; 4.4. сэргээн ашиглах; 4.5. устгах журам зөрчсөн	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.4 дүгээр зүйл.
5. Уул уурхайн олборлолт, боловсруулалтаас үүсэх хог хаягдлыг: 5.1. ангилах; 5.2. цуглуулах; 5.3. тээвэрлэх; 5.4. дахин боловсруулах; 5.5. сэргээн ашиглах; 5.6. устгах журам зөрчсөн	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.5 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
6. Энгийн хог хаягдлыг: 6.1. цэвэрлэх; 6.2. ангилах; 6.3. цуглуулах; 6.4. тээвэрлэх; 6.5. дахин боловсруулах; 6.6. сэргээн ашиглах; 6.7. устгах; 6.8. булшлах журам зөрчсөн	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.6 дүгээр зүйл.
7. Иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдлын талаар хуульд заасан доорх үүргээ биелүүлээгүй зөрчсөн бол 7.1. энгийн хог хаягдлаа ангилан ялгах; 7.2. хог хаягдлаа зориулалтын хогийн сав болон цэгт хаях, эсхүл хог хаягдал цуглуулж тээвэрлэх эрх бүхий байгууллагад шилжүүлэх; 7.3. үүссэн аюултай хог хаягдлаа эрх бүхий байгууллагад, эсхүл тогтоосон тусгай цэгт хүлээлгэн өгөх; 7.4. хог хаягдлын үйлчилгээний хураамжийг тогтоосон хугацаанд төлөх; 7.5. эзэмшлийн барилга, байгууламжийн гадна хана, хашаа, хайсан дээр хог хаягдал болохоор зар сурталчилгаа байршуулахгүй байх; 7.6. нутаг дэвсгэрийн аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдал, цас, мөсийг хариуцан цэвэрлэх 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газрын хог хаягдал, цас, мөсийг цэвэрлэх;	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 30 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.7 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
7.7. барилга барих, буулгах, засварлах үйл ажиллагаанаас гарах хог хаягдлыг цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, устгах, булшлах эрх бүхий иргэн, аж ахуйн нэгж, байгууллагад шилжүүлж, үйлчилгээний хөлсийг хариуцах		
8. Хог хаягдлыг дэд бүтцийн шугам хоолой, эсхүл нийтийн эдэлбэр газар, ногоон бүс, үерийн далан сувагт хаях	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.8 дүгээр зүйл.
9. Хог хаягдлыг ил задгай шатаасан, эсхүл гэрийн болон нам даралтын зууханд нийлэг материалтай хог хаягдлыг шатаах	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.9 дүгээр зүйл.
10. Аж ахуйн нэгж, байгууллага нь хөрс бохирдуулагч жорлон байгуулах	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хуулийн этгээдэд 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.10 дүгээр зүйл.
11. Нийтийн эзэмшлийн эд хөрөнгө дээр зар сурталчилгаа байршуулсан, шашны болон зан үйлийн эд зүйлс тавьж хог хаягдал үүсгэх	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.11 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
12. Хуульд заасны дагуу гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага нь хог хаягдал цуглуулах, тээвэрлэх чиглэл, хуваарийг тогтоож, сум, дүүргийн Засаг даргаар батлуулж мөрдөх үүргээ биелүүлээгүй	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.12 дүгээр зүйл.
13. Хуульд заасны дагуу тогтоосон хуваариар хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэн хог хаягдал сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах үйл ажиллагаа эрхлэх эрх бүхий байгууллагад хүлээлгэж өгөөгүй	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.13 дүгээр зүйл.
14. Энгийн хог хаягдлыг зориулалтын, битүүмжлэлтэй, аюулгүй ажиллагааны шаардлага хангасан тээврийн хэрэгслээр тээвэрлээгүй	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.14 дүгээр зүйл.
15. Хуульд заасны дагуу гэрээ байгуулсан иргэн, аж ахуйн нэгж, байгууллага хог хаягдлыг цэвэрлэх, цуглуулах, тээвэрлэх үед түүнийг унах, асгарах, хийсэхээс сэргийлэх арга хэмжээ аваагүй	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 50 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.15 дүгээр зүйл.
16. Хуульд заасны дагуу гэрээ байгуулаагүй иргэн, аж ахуйн нэгж, байгууллага тухайн үйл ажиллагааг эрхэлсэн бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 30 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.16 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
17. Ногоон байгууламж, амралт, аялал жуулчлал, зуслан, орон сууц, олон нийтийн бүс, усны сан бүхий газар, усны эх үүсвэрийн онцгой болон энгийн хамгаалалтын бүс, хүн амын унд, ахуйн усан хангамжийн тэжээгдлийн мужийн дотор, ашигт малтмалын нөөц нь тогтоогдсон болон бусад хууль тогтоомжоор хориглосон газарт энгийн хог хаягдлыг сэргээн ашиглах, дахин боловсруулах, устгах, булшлах байгууламж байгуулсан бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 5 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.17 дүгээр зүйл.
18. Энгийн хог хаягдлын төвлөрсөн цэгийн болон хог хаягдлыг сэргээн ашиглах, устгах, булшлах үйл ажиллагааг тухайн аймаг, нийслэлийн Засаг даргаас олгосон зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 1 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.18 дүгээр зүйл.
19. Хог хаягдлын төвлөрсөн цэгт аюултай хог хаягдал, халдвартай хог хаягдал, эсхүл шингэн хаягдал, чөлөөт шингэн агуулсан хаягдал булшилсан, шатаасан	Эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 1 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.19 дүгээр зүйл.
20. Тогтоосон цэгээс бусад газарт хог хаягдлын төвлөрсөн цэг байгуулсан, эсхүл энэ төрлийн үйл ажиллагаа эрхэлсэн бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 2 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.20 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
21. Аж ахуйн нэгж, байгууллага нь аюултай хог хаягдал цуглуулах, тээвэрлэх үйл ажиллагааг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын олгосон зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 2 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.21 дүгээр зүйл.
22. Аюултай хог хаягдал хадгалах, устгах байгууламжийг хуулиар байгуулахыг хориглосон байршилд байгуулсан нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 2 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.22 дүгээр зүйл.
23. Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг зөвшөөрөлгүйгээр эрхэлсэн нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.23 дүгээр зүйл.
24. Аюултай хог хаягдал цуглуулах, хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагааг хуульд заасан шаардлагын дагуу эрхлээгүй нь эрүүгийн хариуцлага хүлээлгэхээргүй бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 2 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.24 дүгээр зүйл.
25. Аюултай хог хаягдал хадгалах, дахин боловсруулах, устгах үйл ажиллагаа эрхлэгч нь хууль заасны дагуу холбогдох мэдээллийг байгууламжийг хааснаас хойш 10 жил хадгалах үүргээ биелүүлээгүй бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 200 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 2 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.25 дүгээр зүйл.

Зөрчил	Торгуулийн хэмжээ	Хуулийн заалт
26. Нийтийн эдэлбэр газар, эсхүл ногоон бүсэд энгийн хог хаягдал хаясан бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 300 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 3 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.26 дүгээр зүйл.
27. Аюултай хог хаягдлын жагсаалтад орсон бүтээгдэхүүнийг үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав, баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах, экспортлох үүргээ биелүүлээгүй бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 500 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 5 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.27 дүгээр зүйл.
28. Үйлдвэрлэгч болон импортлогч нь бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг цуглуулж, дахин ашиглах, дахин боловсруулах, сэргээн ашиглах, булшлах, устгах, экспортлох амьдралын мөчлөгийг харуулсан схемтэй байх, эсхүл түүнийг олон нийтэд нээлттэй байлгах үүргээ биелүүлээгүй бол	Учруулсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулна. Мөн хувь хүн – 100 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, Хуулийн этгээдэд 1 000 нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөг байна.	6.1.28 дүгээр зүйл.

ГУРАВ.
ЭНГИЙН ХОГ ХАЯГДЛЫГ ЦЭВЭРЛЭХ,
АНГИЛАХ, ЦУГЛУУЛАХ, ТЭЭВЭРЛЭХ,
ДАХИН БОЛОВСРУУЛАХ, СЭРГЭЭН
АШИГЛАХ, УСТГАХ, БУЛШЛАХ ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

- 1.1. Энэ журмаар нийслэлийн айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагаас үүсэх хог хаягдлыг эх үүсвэр дээр багасгах, ангилан ялгах, ангиллын дагуу хог хаягдлыг цуглуулж, тээвэрлэх, нийтийн эдэлбэр газрыг цэвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах үйл ажиллагааг эрхлэхэд үүсэх харилцааг зохицуулна.
- 1.2. Энэхүү журам нь Хог хаягдлын тухай хууль, түүнд нийцүүлэн гаргасан хууль тогтоомжийн бусад актаас бүрдэнэ.
- 1.3. Энэхүү журмыг нийслэлийн нутаг дэвсгэрт ажиллаж, амьдарч байгаа оршин суугч иргэд, үйл ажиллагаа эрхэлж байгаа аж ахуйн нэгж, байгууллагууд дагаж мөрдөнө.
- 1.4. Энэ журмаар аюултай хог хаягдалтай холбоотой үйл ажиллагааг зохицуулахгүй.
- 1.5. Журмын хэрэгжилтэд мэргэжлийн хяналтын улсын байцаагч, бүх шатны Засаг дарга, цагдаа, хог хаягдлын олон нийтийн байцаагч болон хууль тогтоомжоор эрх олгогдсон албан тушаалтан, гэрээгээр эрх олгосон төрийн бус байгууллага, олон нийтийн хяналтыг иргэдийн бүлэг, иргэн тавина.

Дүүрэг, хорооны засаг дарга болон аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн чиг үүрэг

Дүүргийн Засаг даргын чиг үүрэг	Бүх нийтийн их цэвэрлэгээнд хамрагдах дүүргийн нутаг дэвсгэрийн гудамж, зам, талбай, ногоон бүсийн зураглалыг гаргаж төрийн болон хувийн хэвшлийн аж ахуйн нэгж, байгууллага, их, дээд сургууль, коллеж, ерөнхий боловсролын сургуульд зураглалаар хариуцуулан, хуваарь гарган батлах;	2.4.3. зүйл
	Дүүргийн нутаг дэвсгэр дэх иргэд, аж ахуйн нэгж, байгууллага, Сууц өмчлөгчдийн холбоодод хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгааг журамд заасан арга зүйн дагуу улиралд хоёроос доошгүй удаа тогтмол зохион байгуулах;	2.4.4. зүйл
	Дүүргийн нийтийн эдэлбэр газар, гудамж талбайд хоёроос доошгүй төрлөөр ангилан хогийн савыг журамд заасан байршлуудад байршуулах ба шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгуулах;	2.4.5. зүйл
	Дүүргийн нутаг дэвсгэрт журмын хэрэгжилтийг хангах , нийтийн эдэлбэр газарт ил задгай хог хаягдал үүсгэхгүй байх арга хэмжээг авч ажиллах;	2.4.6. зүйл

	Дүүргийн нийт айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлын ачилт, цуглуулалт, тээвэрлэлтийн үйлчилгээг өмчийн хэлбэрийг харгалзахгүйгээр хуулийн дагуу нээлттэй сонгон шалгаруулалт явуулж, шалгарсан байгууллагатай “Дүүргийн нутаг дэвсгэрт хог хаягдал цуглуулж, тээвэрлэх үйлчилгээ эрхлэх гэрээ” байгуулан гүйцэтгүүлэх;	2.4.7. зүйл
	Дүүргийн нутаг дэвсгэр хог ачиж, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээ үзүүлэх хог хаягдлын үйлчилгээний байгууллагыг журамд заасны дагуу сар бүрийн гүйцэтгэлийн үнэлгээг үндэслэн Хог хаягдлын тухай хуулийн дагуу санхүүжүүлэх ба чанаргүй гүйцэтгэсэн ажлын хувь хэмжээгээр санхүүжилтийг хасаж олгоно.	2.4.8. зүйл
	Аж ахуйн нэгж, байгууллага, иргэний төлөх хог хаягдлын үйлчилгээний хураамжийг Хог хаягдлын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.2-д заасан хэмжээгээр тооцож авахад хяналт тавих, үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлтийг нэмэгдүүлэх;	2.4.9. зүйл
	Хог хаягдлын тухай хуульд заасны дагуу хог хаягдлын тухай хууль тогтоомжийн биелэлтэд хяналт тавих хог хаягдлын олон нийтийн байцаагчийг ажиллуулж, шаардагдах зардлыг тухайн жилийн төсөвт тусгаж батлуулах;	2.4.10. зүйл
	Дүүргийн газар нутгийн онцлогоос хамаарч ангилсан хог хаягдлыг худалдан авах, түр хадгалах цэгийн байршлыг тогтоох;	2.4.11. зүйл
	Зам талбайн цэвэрлэгээг Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчийн Хурлаас баталсан тарифыг үндэслэн цэвэрлэгээний зардлыг дүүргийн төсөвт тусгаж, Төсвийн тухай хуульд заасны дагуу зарцуулах	2.4.12. зүйл
Хорооны Засаг даргын чиг үүрэг	Хорооны иргэд, аж ахуйн нэгж, байгууллагыг дүүргээс зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалт, сурталчилгаанд хамруулах;	2.5.1. зүйл
	Хог ачиж, цуглуулах, тээвэрлэх хуваарийн хэрэгжилтэд хяналт тавих;	2.5.2. зүйл
	Хог хаягдлын олон нийтийн байцаагчийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;	2.5.3. зүйл
	Айл өрх, аж ахуйн нэгж, байгууллагын хог хаягдлыг ангилуулах үйл ажиллагааг зохион байгуулах, хяналт тавих, бүртгэл хөтлөх;	2.5.4. зүйл

	Орон сууц, гэр хорооллын оршин суугч иргэдийн бүх нийтийн их цэвэрлэгээнд оролцсон талаар бүртгэл хөтөлж, өрхийн дэвтэрт тэмдэглэгээ хийх.	2.5.5. зүйл
Аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо, иргэдийн чиг үүрэг	Хуулийн дагуу орчны 50 метр хүртэлх нийтийн эдэлбэр газар, зам талбайн хог хаягдал, шарилж, лууль зэрэг ургамал, цас мөсийг өдөр бүр тогтмол цэвэрлэх;	3.1.1. зүйл
	Тухайн үүргийг гүйцэтгэхгүй тохиолдолд дүүргийн Засаг дарга мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэх бөгөөд гарсан зардлыг тухайн аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо хариуцах;	3.1.2. зүйл
	Аж ахуйн нэгж, байгууллага нь бүх нийтийн их цэвэрлэгээнд ажилтан, албан хаагчдыг хамруулах, холбогдох зардлыг гаргаж цэвэрлэгээний багаж хэрэгслээр хангах;	3.1.3. зүйл
	Журмын дагуу дүүрэг, хорооноос зохион байгуулж буй хог хаягдлын талаарх сургалтад хамрагдах;	3.1.4. зүйл
	Хог хаягдлаа журамд заасны дагуу эх үүсвэр дээр ангилан ялгах;	3.1.5. зүйл
	Аж ахуйн нэгж, байгууллага, сууц өмчлөгчдийн холбоо нь гадна талбайдаа энэхүү журмын 6.2-т заасан төрлөөр хог хаягдал хадгалах сав, бункертэй байх ба доорх шаардлагыг хангасан байх; а. Хогийн сав нь Хог хаягдлын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан ерөнхий шаардлагаас гадна шавьж, мэрэгч, шувуу, амьтан орох боломжгүй хамгаалалт, хаалт, тагтай байна; б. Журмын 6.3-д заасан ангиллын төрлийг заасан таних тэмдэг, өнгөтэй байна; в. Хог хаягдлыг ангилж хийх, хадгалахад хялбар хийц загвартай, өнгө үзэмжтэй байна; г. Хогийн савыг тогтмол цэвэрлэн, сард нэгээс доошгүй удаа ариутгана;	3.1.6. зүйл
	Картон цааснаас бусад төрлийн ангилсан хаягдлыг зориулалтын уутанд хийж, уутны амыг боож битүүмжлэн энэхүү журмын 3.1.6-д заасан хогийн сав, бункерт байршуулан, хадгалах ба хог ачиж цуглуулах хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хог тээврийн авто машинд ачуулах;	3.1.7. зүйл
	Барилга, байгууламжийг өргөтгөх, шинээр барихдаа түүний зориулалт, хүн амын нягтрал, хог хаягдлын үүсэх хэмжээ, ангиллын төрлөөс хамаарч хог хаягдал хадгалах байр, талбайн байршлыг барилга, байгууламжийн зураг, төсөлд тусгасан байх;	3.1.8. зүйл

0,75м.кубээс дээш эзлэхүүнтэй овор хэмжээ их энгийн болон барилгын хог хаягдлыг хуульд заасны дагуу нэмэлт үйлчилгээний хөлс төлж эрх бүхий мэргэжлийн байгууллагаар тээвэрлүүлэх;	3.1.9. зүйл
Хог хаягдлаа эрх бүхий мэргэжлийн байгууллагатай “Хог ачиж, тээвэрлүүлэх гэрээ” байгуулж, ангиллын төрөл тус бүрээр хогоо ачуулах ба уг гэрээнд хог ачих өдөр, цаг, давтамжийг тодорхой заах;	3.1.10. зүйл
Хог хаягдал ачиж цуглуулах эрх бүхий мэргэжлийн байгууллага нь хуваарийн дагуу ангиллын төрөл тус бүрээр хогоо ачаагүй тохиолдолд Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба, дүүргийн Засаг даргад уг байгууллагын үйл ажиллагааг сайжруулах арга хэмжээ авах , 3-аас дээш удаа хуваарийн дагуу хогоо ачаагүй тохиолдолд журмын 2.4.7-д заасан гэрээг нь цуцлуулах, хүчин чадал бүхий өөр байгууллагаар тээвэрлэлт хийлгүүлэхийг шаардах;	3.1.11. зүйл
Бүх нийтийн их цэвэрлэгээний өдрүүдэд дүүргээс зураглалаар хариуцуулсан нийтийн эдэлбэр газар, гудамж, зам, талбайн хог хаягдлыг цэвэрлэж, холбогдох байгууллагад хүлээлгэж өгөх;	3.1.12. зүйл
Хүнсний зах, супермаркет, худалдаа үйлчилгээний төвүүд иргэдэд авсан бараагаа савлах цэгийг байгуулж, цаасан хайрцгаар хангах;	3.1.13. зүйл
Нийслэлд үйл ажиллагаа эрхлэгч аж ахуйн нэгж, байгууллага нь дараах бүтээгдэхүүний хаягдал, тэдгээрийн сав баглаа боодлоос үүсэх хог хаягдлыг эргүүлэн цуглуулах, дахин ашиглах, дахин боловсруулах үйл ажиллагааг хариуцах; а. PET төрлийн хуванцар сав; б. Шилэн лонх, сав; в. Авто тээврийн хэрэгсэл болон өөрөө явагч хэрэгслийн дугуй; г. Хөнгөн цагаан болон металл лааз, сав;	3.1.14. зүйл
Нийслэл хотод үйл ажиллагаа эрхэлж байгаа согтууруулах ундаа үйлдвэрлэгч аж ахуйн нэгжүүд нийт борлуулсан согтууруулах ундааны шилэн лонхныхоо 30-аас доошгүй хувийг эргүүлэн татаж, дахин ашиглах;	3.1.15. зүйл
Хог хаягдлыг үүсгэгч нь журмын 3.1.14, 3.1.15 дахь заалтыг дангаар болон хамтран хэрэгжүүлж болно.	3.1.16. зүйл

Нийтийн их цэвэрлэгээ зохион байгуулах

Нийтийн их цэвэрлэгээнд тавигдах шаардлага	Цэвэрлэсэн хог хаягдлыг ил задгай овоолон орхих, шатаахгүй байх;	5.2. зүйл
	Цэвэрлэгээнээс гарсан хог, хаягдлыг тусгайлсан уутанд хийж, уутны амыг боон хог хаягдал ачихаар тодорхойлсон байршилд хүргэх;	
	Хөдөлмөр, эрүүл ахуйн аюулгүй ажиллагааг ханган цэвэрлэгээнд оролцож байгаа иргэдэд амны хаалт, бээлий хэрэглүүлэх;	
	Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдыг багш, эцэг эхийн хараа, хяналтын дор бүх нийтийн цэвэрлэгээнд оролцуулах.	

Энгийн хог хаягдлыг ангилах

Хог хаягдлыг ангилах гэж Хог хаягдлын тухай хуулийн 4.1.7 дахь заалтад заасныг ойлгоно.		6.1 зүйл
Энгийн хог хаягдлыг эх үүсвэр дээр дараах байдлаар ангилна. а. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал; б. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал; в. Хүнсний органик хог хаягдал;		6.2 зүйл
Орон сууцны айл өрх, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.	а. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал; б. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал; в. Хүнсний органик хог хаягдал	6.2.1. зүйл
Гэр хорооны айл, өрх, аж ахуйн нэгж, байгууллага энгийн хог хаягдлыг хамгийн багадаа дараах төрлөөр ангилна.	а. Дахин боловсруулах боломжтой хог хаягдал; б. Дахин боловсруулах боломжгүй хог хаягдал; в. Үнс буюу шаарга; г. Хүнсний органик хог хаягдал	6.2.2. зүйл
Хог хаягдлын төрлийг дараах өнгөөр илэрхийлнэ.	а. Хуванцар, гялгар уут – Ногоон; б. Хөнгөн цагаан лааз, металл хаягдал – Улбар шар; в. Цаас – Цэнхэр; г. Шил – Цагаан; д. Хүнсний органик хаягдал – Бор; е. Бусад хог хаягдал – Хар; ж. Ахуйн аюултай хог хаягдал – Шар.	6.3. зүйл

ДӨРӨВ.
ХОГ ХАЯГДЛЫН ОЛОН НИЙТИЙН
БАЙЦААГЧ АЖИЛЛУУЛАХ,
МӨНГӨН УРАМШУУЛАЛ ОЛГОХ
ЖУРАМ

Нийтлэг үндэслэл

- 1.1 Нийслэлийн нутаг дэвсгэрийн хэмжээнд Хог хаягдлын тухай хуулийн хэрэгжилтэд хяналт тавих олон нийтийн байцаагчийн үйл ажиллагааг зохицуулахад энэхүү журмын зорилго оршино.
- 1.2 Энэхүү журмаар хог хаягдлын олон нийтийн байцаагч /цаашид “олон нийтийн байцаагч” гэх/-ийг ажиллуулах, түүнд мөнгөн урамшуулал олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.
- 1.3 Олон нийтийн байцаагч үйл ажиллагаандаа Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

Олон нийтийн байцаагч чиг үүргээ хэрэгжүүлэхдээ дараах зарчмыг удирдлага болгоно	Бусдын нөлөөнд үл автах, ашиг сонирхлын зөрчлөөс ангид байх;	1.4. зүйл
	Бусдын эрх, хууль ёсны ашиг сонирхол, нэр төрийг хүндэтгэх;	
	Асуудалд бодитой хандаж, хяналтыг зөвхөн нотлох баримтад тулгуурлах;	
	Албан үүргээ гүйцэтгэх явцдаа олж мэдсэн төрийн болон албаны, хувь хүний хуулиар хамгаалагдсан нууцыг задруулахгүй байх, хувийн болон бусдын ашиг сонирхлын төлөө ашиглахгүй байх.	

- 1.5 Улаанбаатар хотын Захирагчийн ажлын алба энэхүү журмын хэрэгжилтэд хяналт тавина.

Олон нийтийн байцаагчид тавигдах шаардлага, түүнийг томилох

Дүүргийн нутаг дэвсгэрийн хэмжээ, хүн амын төвлөрлийн байдлаас хамаарч хороо бүрт нэгээс доошгүй олон нийтийн байцаагч ажиллуулах бөгөөд олон нийтийн байцаагчийн тоо, олгох урамшууллын хэмжээг тухайн дүүргийн Засаг дарга батлагдсан төсвийн хязгаарт нийцүүлэн тогтооно	2.1. зүйл
--	--------------

Олон нийтийн байцаагчийн ажлын байранд нээлттэй сонгон шалгаруулалт зарлаж, дараах шаардлагыг хангасан иргэнээс сонгон авна. Үүнд: • 18-аас дээш насны, иргэний эрх зүйн бүрэн чадамжтай, бүрэн дундаас дээш боловсролтой Монгол Улсын иргэн байх; • иргэдийн итгэл хүлээсэн, шударга, зарчимч, хууль тогтоомж сурталчлах зохион байгуулах, багаар ажиллах, бусдад хуулийн хүрээнд шаардлага тавих чадвартай байх; • тухайн дүүрэг, хороонд албан ёсоор бүртгэлтэй, байнгын оршин суугч байх; • гэмт хэрэг зөрчилд холбогдож байгаагүй, хэл яриа, харилцааны соёлтой байх; • Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль тогтоомжийн талаар бүрэн мэдлэгтэй байх; • ухаалаг утас хэрэглэх, цахим орчинд ажиллах, интернет, компьютерийн анхан шатны программууд ашиглах чадвартай байх.	2.2. зүйл
Дүүргийн Засаг даргын зөвлөлийн хурлын шийдвэрийг үндэслэн Олон нийтийн байцаагчийг дүүргийн Засаг даргын захирамжаар 2 жилийн хугацаагаар томилно.	2.4. зүйл
Олон нийтийн байцаагчаар томилсон дүүргийн Засаг даргын захирамжийг үндэслэн Тамгын газрын дарга Олон нийтийн байцаагчтай энэ журмын Хавсралт №2-т заасан хөлсөөр ажиллах гэрээг байгуулах ба гэрээнд хариуцах ажил, талуудын харилцан хүлээх үүрэг, урамшуулал, гэрээ цуцлах үндэслэлийг тусгана.	2.5. зүйл
Олон нийтийн байцаагч нь энэхүү журмын Хавсралт №4-т заасан ажлын төлөвлөгөө болон энэ журамд заасан чиг үүргийн дагуу ажлаа сар, улирлаар төлөвлөн дүүргийн Засаг даргын Тамгын газрын хог хаягдлын асуудал хариуцсан нэгжийн даргаар батлуулах ба хорооны Засаг дарга болон дүүргийн Засаг даргын Тамгын газрын хог хаягдлын асуудал хариуцсан мэргэжилтний удирдлага дор ажиллана.	2.6. зүйл
Энэ журамд заасан шаардлагыг хангаагүй ажилтанг Олон нийтийн байцаагчаар томилохгүй.	2.7. зүйл

Олон нийтийн байцаагчийн чиг үүрэг, зөрчлийн тэмдэглэл үйлдэх

Олон нийтийн байцаагч нь дараах чиг үүрэгтэй	Хог хаягдлын тухай хууль, Зөрчлийн тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомж, тэдгээртэй нийцүүлэн гаргасан эрх бүхий байгууллагын шийдвэр, нийслэл, дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын тогтоол, бүх шатны Засаг даргын захирамжийг сурталчлах, хэрэгжилтэд хяналт тавих;	3.1. зүйл
	Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн цэвэрлэгээ, барилга байгууламжийн засварын хог хаягдалд хяналт тавих, орон сууцны болон гэр хорооллын гудамж, зам талбайд ил задгай хог хаягдал үүсэхээс урьдчилан сэргийлэх, гарсан зөрчлийг арилгуулах арга хэмжээ авах;	
	Аж ахуйн нэгж, байгууллага, айл өрхүүд өөрийн эзэмших, ашиглах, өмчлөх эрх бүхий газрын хил заагаас 50 м-ийн эргэн тойрон дахь нийтийн эзэмшлийн талбайн цас мөсийг тогтмол цэвэрлэх, орчныг бохирдолгүй цэвэр байлгах үүргээ хэрэгжүүлж байгаа эсэхэд хяналт тавих, хэрэгжүүлэх шаардлага тавих;	
	Байнга болон түр оршин суудаг айл өрх, аж ахуйн нэгж байгууллагын хог цуглуулалт, тээвэрлэлт, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн орлого төвлөрүүлэлт болон гэрээний биелэлтэд хяналт тавих;	
	Байгаль экологи, хүрээлэн буй орчинд сөргөөр нөлөөлөх үйлдлийг таслан зогсоох, илэрсэн зөрчил, дутагдлыг арилгуулах арга хэмжээ авч эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх;	
	Хорооны нийтийн эдэлбэр газрын цэвэрлэгээ, хог хаягдлын тээвэрлэлтийн үйл ажиллагаанд, хяналт тавих, аж ахуйн нэгж байгууллагын идэвх санаачилгыг өрнүүлэх;	
	Бүх нийтийг хамарсан хог цэвэрлэгээний ажилд иргэд, байгууллага, аж ахуйн нэгжийг өргөнөөр хамруулах, зар түгээх, сурталчлах;	
	Хог хаягдлын талаарх олон нийтийн боловсролыг дээшлүүлэх ажилд холбогдох төрийн болон төрийн бус байгууллага, хорооны Засаг даргатай хамтран ажиллах;	

	Хог хаягдлыг бууруулах, эдийн засгийн эргэлтэд оруулах санал санаачилга гаргах, зохион байгуулах үүрэг бүхий орон тооны бус иргэдийн бүлэг байгуулж ажиллуулах талаар хорооны Засаг даргад туслах, хамтарч ажиллах; Сууц өмчлөгчдийн холбооны хог хаягдлыг ангилан ялгах, цуглуулах үйл ажиллагаа болон хог хаягдлын менежментийн үйл ажиллагааны хэрэгжилтэд хяналт тавих; Тухайн нутаг дэвсгэрт тогтоосон агаарын чанарыг сайжруулах хязгаарлалтын бүсийн журам, дүрмийн хэрэгжилтэд хяналт тавих; Хог хаягдлын тухай хууль тогтоомжийг зөрчсөн зөрчил, дутагдлыг арилгуулах, удаа дараа зөрчил гаргасан, тавьсан шаардлагыг биелүүлээгүй иргэн, аж ахуйн нэгж байгууллагад хууль тогтоомжид заасан хариуцлагыг тооцуулах саналыг эрх бүхий албан тушаалтанд мэдэгдэх.	
Зөрчлийн тэмдэглэлийг үйлдэх	Илэрсэн зөрчлийн талаар журмын Хавсралт №3-т заасан маягтын дагуу зөрчлийн тэмдэглэлийг үйлдэх ба тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана. Үүнд: 1. Зөрчил гаргасан байгууллага, аж ахуйн нэгж, иргэний нэр, утас, хаяг, байршил, регистрийн дугаар, үйл ажиллагааны чиглэл; 2. Гаргасан зөрчлийн нөхцөл байдал; 3. Зөрчигдсөн хууль тогтоомжийн зүйл, заалт; 4. Олон нийтийн байцаагчийн санал, дүгнэлт / Захиргааны шийтгэл ногдуулах хууль тогтоомжийн зүйл, заалтыг тусгасан байх/.	3.6. зүйл
Олон нийтийн байцаагчид мөнгөн урамшуулал олгох, гэрээг цуцлах	Дүүргийн Засаг даргын өргөн мэдүүлснээр дүүргийн Иргэдийн төлөөлөгчдийн Хурал жил бүр Олон нийтийн байцаагчийн мөнгөн урамшуулал болон дүрэмт хувцас, ажлын үнэмлэхтэй холбогдох зардлыг дүүргийн төсөвт тусгаж, санхүүжүүлнэ.	4.1. зүйл
	Дүүргийн Засаг даргын Тамгын газар энэ журмын 4.1-д заасны дагуу батлагдсан төсвийн хүрээнд олон нийтийн байцаагчид хөлсөөр ажиллах гэрээнд тусгасан мөнгөн урамшууллыг сар бүр олгоно.	4.2. зүйл

	Олон нийтийн байцаагч нь сар бүрийн 25-ны дотор тухайн сард хийж гүйцэтгэсэн ажлын тайланг Хавсралт №4-т заасны дагуу гаргаж, энэ журмын Хавсралт №6-д заасан ажлын үнэлгээний хамт дүүргийн Засаг даргын Тамгын газарт ирүүлэх бөгөөд ажлын гүйцэтгэл, үнэлгээг үндэслэж мөнгөн урамшууллыг олгоно.	4.3. зүйл
	Олон нийтийн байцаагчийн тухайн сарын ажлын мөнгөн урамшууллыг энэ журмын Хавсралт №6-д заасан ажлын үнэлгээний маягтын дагуу илрүүлсэн зөрчлийн тоо, чанар, үр дүнг үнэлэн тооцох ба нэг сард олгох урамшуулал нь хувь хүний орлогын албан татвар, эрүүл мэнд, нийгмийн даатгалын шимтгэл зэргийг суутгасны дараах дүн нь хөдөлмөрийн хөлсний доод хэмжээнээс багагүй байна.	4.4. зүйл
	Дүүргийн Засаг даргын Тамгын газар нь Олон нийтийн байцаагчийн ажлыг Хавсралт №6-д заасан маягтын дагуу гаргасан үнэлгээнд үндэслэн тухайн жилд нэг удаагийн нэмэлт урамшууллыг дүүргийн төсөвт тусган олгож болно.	4.5. зүйл
	Олон нийтийн байцаагч нь Хог хаягдлын тухай хууль тогтоомж зөрчсөн зөрчлийн талаар эрх бүхий байгууллагад мэдэгдэж , тус хуулийн 41 дүгээр зүйлийн 41.13-т заасны дагуу зөрчил гаргагчид ногдуулсан торгуулийн 15 хувиар тооцож , дүүргийн Засаг даргаас мөнгөн урамшуулал авч болно.	4.6. зүйл
	Дараах тохиолдолд олон нийтийн байцаагчтай байгуулсан гэрээг захиргааны байгууллагын санаачлагаар цуцална. Үүнд: • Энэ журмаар хүлээсэн чиг үүргээ удаа дараа зөрчсөн; • Үүрэгт ажилдаа шударга бус хандаж эрхээ хэтрүүлсэн; • Өөр ажил, албан тушаалд томилогдох болсон; • Гэмт хэрэг үйлдсэн нь нотлогдож шүүхийн таслан шийдвэрлэх тогтоол хүчин төгөлдөр болсон; • Нас барсан; • Өөрийн хүсэлтээр гарахаар өргөдөл өгсөн; • Энэхүү журмын хавсралт №6-д заасан нийлбэр үнэлгээний дундаж 3 сар дараалж 1 оноогоор үнэлэгдсэн.	4.10. зүйл

